



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/А24

Булган сум

**Мөсөн дээгүүр хөдөлгөөн
хийхийг хориглох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн нутаг дэвсгэр дэх гол, мөрөн, нуур, цөөрмийн мөсний зузаан Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 193 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтээр судалгаанд хамрагдсан голуудын эрэг дагуух мөсний зузаан 06-22 см байгаа нь мөс цөмрөх эрсдэлтэй байх тул 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд мөсөн дээгүүр хөдөлгөөн хийхийг хориглосугай.

2.Сумын нутаг дэвсгэрт орших гол, мөрөн, нуур, цөөрмийн мөсөн дээгүүр явганаар, бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр явах болон мал туух зэрэг хөдөлгөөн хийхийг хориглох, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, мөс цөмрөх аюулаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх, гарам бүхий газрын ойролцоо амьдардаг малчин өрхүүдээр хөдөлгөөнт хяналт тавиулах ажлыг зохион байгуулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Мөсөнд цөмрөх аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах алба (Э.Эрболд)-д даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг), Авто тээврийн төв (Н.Баасанжаргал), сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР